



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 03 сарын 07 өдөр

Дугаар А/07

Мөрөн сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.3, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаал, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн ээлжит XXIII хуралдааны 04 дүгээр тогтоол, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2024 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн 7 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Бүгд Найрамдах Солонгос Улсад болох олон улсын хамтарсан бэлтгэлд явах Мөрөн сумын иргэн марафон гүйлтийн тамирчин Ш.Түмэнбаярын замын зардалд 500,000 (таван зуун мянга) төгрөг, Цагааннуур сумын иргэн Монголын боксын холбооны гишүүн боксын спортын тамирчин С.Биндэрьяагийн “Лос-Анжелес 2028” зуны олимпод оролцох бэлтгэлийн зардалд 500,000 (таван зуун мянга) төгрөг, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар, Мөрөн сумын Засаг даргын Тамгын газраас санаачлан зохион байгуулсан “Бид ирээдүйн эзэд” сургалтын зардалд 500,000 (таван зуун мянга) төгрөг, Бүгд Найрамдах Хятад ард Улсад болох Олон Улсын Таеквондогийн тэмцээнд оролцох Мөрөн сумын Эрдмийн далай цогцолбор сургуулийн сурагч О.Амаржаргалын замын зардалд 500,000 (таван зуун мянга) төгрөгийн дэмжлэгийг тус тус олгосугай.

2.Дээрх зардлын 2,000.000 (хоёр сая) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөнөөс гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Э.Улам-Өсөх), нягтлан бодогч (Э.Анхцэцэг)-д зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс (Б.Батбилгүүн)-т даалгасугай.

ДАРГА

П.ЛХАГВАЖАВ

